



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/676

Булган сум

Г Газар эзэмших эрхийг хэсэгчлэн шилжүүлэх тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Цэцэгжин" ХХК (РД:2008181)-ны Булган сум 5 дугаар баг Хатанбаатар С.Магсаржав 2 дугаар гудамж 223 тоотод байршилтай 6308009331 нэгж талбар бүхий худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 3294 м2 газраас 28 м2 газрыг иргэн Г.Ганцэцэг (ГЖ86100904)-т, 31 м2 газрыг Б.Батжаргал (ГЕ69122704)-т тус тус хэсэгчлэн шилжүүлж, үлдсэн 3235 м2 газрыг "Цэцэгжин" ХХК-д үлдээн эзэмшүүлсүгэй.

2. "Цэцэгжин" ХХК-ийн захирал М.Болд, иргэн Г.Ганцэцэг, Б.Батжаргал нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны А/105 дугаар захирамжийн "Цэцэгжин" ХХК-тай холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

